# Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

## Налайхын үйлдвэрлэл технологийн парк ХК

## 2025 оны жилийн эцэс

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| ЗГ-ын тогтоол | | | | | | | |
| 8 | 8 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_203 | 1. 1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай: 1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх; 1.2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх; 1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах; 1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон | Төсөв санхүүгийн үйл ажиллагаанд хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар төсвөөс 0.5 хувийн хэмнэлт гаргасан. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журмын хэрэгжилтийг тухай бүр байгууллагын вэб сайт болон мэдээллийн самбарт мэдээллэн ажиллаж байна. | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх. | | | | | |
| 18 | 34 | 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай 2023-02-08 Дугаар 2023_49 | Х-1.2. Шүгэл үлээх үйл ажиллагааг бүх талаар дэмжих хөдөлгөөн зохион байгуулж, авлигыг үл тэвчих, үл эвлэрэх хандлагыг төлөвшүүлэх, олон нийтийн дэмжлэг авах; | Байгууллагын авилгалын эсрэг үйл ажиллаганы төлөвлөөг боловсруулж батлуулан 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргасан.<br>2025 оны 03 сарын 18-ны өдөр дураараа аашлах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн талаарх сургалтыг зохион байгуулсан. | 100 | | | |
| | 35 | | | | | | | |
| 46 | 72 | Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215 | 2.. Төрийн байгууллага өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, үүнтэй холбогдсон гомдлыг Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан авч, зөрчил гаргасан албан тушаалтанд хуульд заасан үндэслэл, журмын дагуу хариуцлага тооцож байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай | Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем (Docx)-ийг ашиглан 2025 оны жилийн эцсийн байдлаар хүлээн авсан бичиг 330, байгууллагаас өөр байгууллага хооронд илгээсэн бичиг 318 байна. | 100 | | | |
| 140 | 241 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 3 | 3.12.3.1. Шуурхай штабаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг яаралтай зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар нарт | 1. Улс, нийслэлийн төсвөөс нийт 29,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж дараах дэд бүтцийн болон судалгааны бичиг баримт, | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дугаар тэмдэглэл 2025-01-14 Дугаар 2025_03 | даалгав;(Монгол Улсын Засгийн газраас “2025 оныг нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, салбар хоорондын зохицуулалт, шуурхай удирдлагаар хангах Шуурхай штабын анхдугаар хуралдааны талаар ) | зураг төслийн ажлууд хийгдсэн. Үүнд:<br>- Паркийн оффисын барилга<br>- Авто зам<br>- Гүний худаг<br>- Үерийн далан<br>- Түр цахилгаан хангамж<br>- ТЭЗҮ<br>- ХЕТ<br>- Усны эрэл хайгуул<br>- БОННҮ<br>- Дэд бүтцийн ажлуудын зураг төсөл<br>3.Паркийн үндсэн цахилгаан хангамжийн ажил хийгдэж энэ оны 2 дугаар улиралд улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтад оруулахаар төлөвлөсөн.<br>4.Мөн 130га газрын Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийгдэж ХББОС яамны мэргэжлийн зөвлөлөөр батлагдан 3 сард хүлээн авсан. | | | |
| 152 | 314 | ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ | 2.16.2.16.Багануур, Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Эрчим хүчний сайд | Налайх үйлдвэрлэл технологийн паркийн 2025 оны өнөөгийн байдлаар Цахилгаан хангамжийн БУ-ын ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Уг барилга | | | Багануур, Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк, Налайхын барилгын материалын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ТУХАЙ<br>2025-03-06<br>Дугаар 2025_02 | Б.Чойжилсүрэн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт | байгууламжийн “Налайх 110/35/10 кВ-ын дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил” бүрэн дууссан, дэд станцаас Паркийн 110/10 кВ-ын дэд станц хүртэлх 110 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил” бүрэн дуусаж техникийн комисс ажилсан. Дэд станцаас паркийн 110/10 кВ-ын дэд станц хүртэлх 110 кВ-ын 2 хэлхээт 9,8 км цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил бүрэн дуусаж агаарын шугамын хүчдэлээ өгч техникийн комисс ажиллаж тодорхой үүрэг даалгавар өгч үүрэг даалгаврын биелэлтээр техник комисс хүлээж авахаар болсон. Паркийн хэмжээнд нийт 15 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах газарт үйлдвэрийн барилга байгууламжийн угсралтын ажлаа эхлүүлж бүтээн байгуулалтын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байнгаа бөгөөд 5-н үйлдвэр | | | үйлдвэрлэл, технологийн парк, Эмээлт эко аж үйлдвэрийн парк |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлж байна. | | | |
| 154 | 346 | ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАСТ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2025-03-07 Дугаар 2025_03 | 1.25. 1.25. Албан даалгаврын хэрэгжилтийн явцыг сар бүр дүгнэж, мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх. | “Алсын хараа 2050”, Шинэ сэргэлтийн бодлого, ЗГ-ийн үйл ажиллагааны хөтөлбөр 2024-2028, НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр 2024-2028 бодлогын бичиг баримтуудад паркийн дэд бүтцийн ажлуудыг дуусгахаар тусгагдсан бөгөөд Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд:<br>- дулаан хангамжийн барилгын ажил<br>-цэвэрлэх байгууламж, ариутгах татуурга барих ажил<br>-гадна цахилгаан хангамжийн зураг төсөв хийх<br>-бөөний болон жижиглэн худалдааны төвийн төлөвлөлт /ХЕТ/-ийн ажлууд тусгагдсан. | | | |